

**ЗАЙНААС ТАНДАН СУДАЛГААНЫ АРГААР АГААРЫН БОХИРДОЛ  
ТОДОРХОЙЛОХ СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

№	АГУУЛГА
1	Зорилго  “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхай болон түүний орчмын тоосжилт, агаарын бохирдлын эх үүсвэрийг тодорхойлон бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолох.
2	Зорилт  Сургалтын хэрэгцээнд үндэслэн хамрагдах хүрээг хангаж чадахуйц чанартай, үр дүнтэй сургалтыг авах.
3	Хэрэгцээ, шаардлага  Уурхайн тоосжилт, агаарын бохирдоос шалтгаалан байгаль орчин болон эрүүл мэндэд сөрөг нөлөө учирдаг ба тэдгээрийг тодорхойлж, арга хэмжээ авахад судалгаа, шинжилгээ шаардлагатай.
4	Сэдэв  Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах; <ul style="list-style-type: none"> <li>• Газарзүйн мэдээллийн систем ашиглан тоосны тархалтыг тодорхойлох;</li> <li>• Орчны агаарын бохирдол хэмжих, үнэлэх арга зүйн мэдлэгийг өгөх;</li> <li>• Сансрыйн зургаар орчны агаарын тоосжилт, бохирдлыг тооцоолох;</li> <li>• GIS, ENVI, Aermod программ ашиглан агаарын бохирдол, тоосжилтыг урьдчилан тооцоолох;</li> <li>• Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосны хэмжилтийн дата модоог цаг агаарын мэдээтэй улдуулсан тархалтын тархалтын зураг боловсруулах.</li> </ul>
5	Хэлбэр  Онол болон практик хосолсон байдлаар
6	Тавигдах شاардлага  <u>Сургалтын байгууллагад:</u> <ul style="list-style-type: none"> <li>• Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх;</li> <li>• Тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай;</li> <li>• Сүүлийн 2 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай;</li> <li>• Тухайн чиглэлийн мэргэшсэн, мэргэжлийн туршлагатай багш нартай байх;</li> <li>• Цахим сургалтыг явуулж байсан туршлагатай байх;</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах;</li> <li>• Сургалтын зориулалтын анги танхим, дадлага хийх тоног төхөөрөмжтэй байх;</li> <li>• Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх, сертификат олгох;</li> <li>• Сургалтад хамрагдаж буй ажилтнуудын ажлын суурин компьютерт ашиглах программыг суулгаж өгөх.</li> </ul>

		<p><u>Сургагч багшид:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургагч багш нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх;</li> <li>• Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай;</li> <li>• Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалт явуулах;</li> <li>• Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх;</li> <li>• Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах.</li> </ul>
7	Хамрах хүрээ	Салбарын Байгаль орчин, усны бодлогын хэлтсийн 5 мэргэжилтэн
8	Хугацаа	<p>2021 оны III, IV улиралд зохион байгуулах</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” ЖК-ийн уурхайн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах.</p>
9	Төсөв	Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжлийн үнэмлэх /сертификат/ болон бусад зардал
10	Үр дүн	Мэргэжлийн ур чадвартай болж ажлын бүтээмж нэмэгдэнэ.